

САНАЛ АВАХ БАЙРАНД ОЧИЖ, САНАЛАА ӨГӨХ

Сонгогч саналаа өгөх дарааллыг сонгуулийн тухай хууль тогтоомжоор зохицуулсан байдаг. Улсын Их Хурал нөхөн сонгуулийг санал авах өдрийн хамт товлон зарласан бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргийн УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийн санал авах ажиллагаа **2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатарын цагаар өглөөний 07:00 цагаас оройн 22:00 цаг хүртэл** үргэлжилнэ. Дээрх тойргийн сонгогч Та өөрийн байнга оршин суугаа газрын харьяа хэсгийн санал авах байранд очиж санал өгөх ёстой.

Сонгогч санал авах байранд иргэний үнэмлэх, эсвэл түүнийг орлох бичиг баримттай ирж, саналаа биечлэн өгнө. Ингэхдээ саналын хуудсанд бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээг хийж саналаа өгнө. Гарын хурууны хээгээр нь сонгогчийг



баталгаажуулж, саналын хуудас олгох бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна. Хэрэв гарын хурууны хээгээр нь сонгогчийг таних боломжгүй бол сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж, сонгогчийн бүртгэлийн хуудас олгох юм. Сонгогч санал бэлтгэх бүхээгт нууцаар саналаа тэмдэглэнэ. Хэсгийн хорооны

дарга, гишүүд болон холбогдох бусад этгээд сонгогчийн саналын нууцлалыг алдагдуулахыг хориглодог. Сонгогч саналаа тэмдэглэсний дараа саналын нууцлалыг хангах зориулалт бүхий хавтас хэрэглэж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийнэ. Ингэснээр сонгогчид саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээг хэсгийн хорооны ажилтан хийж өгнө. Бэхэн тэмдэглэгээг зөвхөн нэг удаа хийх бөгөөд сонгогч тэмдэглэгээ хийх заавартай танилцах боломжтой. Сонгогч санал тэмдэглэхдээ алдаа гаргаж, буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжид хийхээс өмнө энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, саналаа өгч болно. Мөн санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүй бол сонгогч энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, уг саналын хуудсыг хураалгаж, дахин саналын хуудас авч, саналаа өгч болно. Санал авах өдрийн 22:00 цагт сонгогчийн бүртгэл зогсох бөгөөд бүртгэлийн хуудсаа 22:00 цагаас өмнө авсан бол

СОНГОГЧ САНАЛ ӨГӨХ АЛХАМ

